

ЗАСАГ ДАРГА

БАТЛАВ

Х ХҮРЭЛЧУЛУУН



ДОРНОД АЙМАГ БАЯНДУН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Огноо: 2019.09.11

**МАЛЧДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨГЖЛИЙН ДЭД  
ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД МАЛЧИН ӨРХИЙГ МАЛЖУУЛАХ  
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Харьцуулалт:**

Мах-ноосны чиглэлийн үржлийн эм хонь нийлүүлэх  
ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах

**гэрээний дугаар:**

БД-2019/03

Наранбулаг  
2019 он

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |      |  |
|---|------|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2. Тогтмол үнэ</b>                                   | 2.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.  |
| <b>3. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 3.1. | Нийлүүлэх бараа нь энд заасан техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд үүнийг заавал мэдэгдэнэ.   |
|   | 3.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг батлах үүрэгтэй.   |
| <b>4. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 4.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>14</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| <b>5. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>            | 5.1. | Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.   |
|   | 5.2. | Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <b>нэг</b> багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.  |
|   | 5.3. | Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.  |
| <b>6. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</b>      | 6.1  | Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

### Гурав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |      |  |
|---|------|--|
| <b>1. Шалгах болон турших</b>                             | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д , эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b> | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |

- |   |  |
|---|--|
| <b>3. Оюуны өмчийн эрх</b>                            | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| <b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b> | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.   |
| <b>5. Баталгаат засварын хугацаа</b>                  | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа байна.   |
| <b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>                    | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.  |
| <b>7. Төлбөр</b>                                      | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[moo]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| <b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>                     | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.  |
| <b>9. Алданги оногдуулах</b>                          | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.                 |
| <b>10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах</b>    | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| <b>11. Маргааныг шийдвэрлэх</b>                       | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

**Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

| <b>ТООЗ-ны холбогдох заалт</b> | <b>Шалгуур үзүүлэлт</b>  |
|--------------------------------|--|
| ТООЗ 1.1                       | <p>Тендерт оролцогч нь Орон нутгийн төсвийн зардлаас хөрөнгөөр санхүүжих 16.000.000.0 төгрөгийн төсөвт өртэгтэй “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр” гүйцэтгэх ажилд дараах мэдээллийг үнийн саналын хамт ирүүлнэ. Тендерт оролцогч нь “Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь”-т заасан барааг нийлүүлэх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:</p> <p><b><u>Иргэн:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 оны малын А данс</li> <li>• Малын эрүүл мэндийн дэвтрийн хуулбар</li> <li>• Тухайн сууринд сүүлийн 3 жилд шүлхий өвчин, 1 жил паразит өвчин, сүүлийн 20 хоног боом өвчин гараагүй байх тухай мал эмнэлэгийн тодорхойлолт</li> <li>• Малчны тамганы дардасын хуулбар</li> <li>• Нийлүүлэх хонийг өөрийн зардлаар авчирч өгөх</li> <li>• ЗДТГ-ын дансанд бүртгэгдэх тул нийлүүлж буй эм хонины им зүс, тэмдгийн цуваа жагсаалттай байх</li> </ul> <p><b><u>Аж ахуй нэгж:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Тухайн сууринд сүүлийн 3 жилд шүлхий өвчин, 1 жил паразит өвчин, сүүлийн 20 хоног боом өвчин гараагүй байх тухай мал эмнэлэгийн тодорхойлолт</li> <li>• Нийлүүлэх хонийг өөрийн зардлаар авчирч өгөх</li> <li>• ЗДТГ-ын дансанд бүртгэгдэх тул нийлүүлж буй эм хонины им зүс, тэмдгийн цуваа жагсаалттай байх</li> </ul> <p>Дурдсан мэдээлэл, холбогдох баримтыг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p> |
| ТООЗ 2.1                       | <p><b>Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг:</b><br/> Дорнод аймгийн Баяндун сум Наран баг сумын ЗДТГ<br/> Утас: 89968586, 88617192<br/> Цахим шуудан: batsaroyu@gmail.com</p>  |
| ТООЗ 2.1                       | <p><b>Тендер хүлээн авах хаяг:</b><br/> Дорнод аймгийн Баяндун сум Наран баг, сумын ЗДТГ 2 давхар сумын Засаг даргын орлогч Б.Бат-Эрдэнэ<br/> <b>Хүлээн авах эцсийн хугацаа нь:</b><br/> Огноо: 2019.06.<br/> Цаг: 10 цаг 00 минут</p>   |
| ТООЗ 2.1                       | <p><b>Тендер нээлт хийх газар, хугацаа нь:</b><br/> Дорнод аймгийн Баяндун сумын Наран баг, сумын Засаг даргын тамгын газрын 2-р давхар Иргэний танхим<br/> Утас: 89968586,88617192<br/> Цахим шуудан: batsaroyu@gmail.com<br/> <b>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:</b><br/> Огноо: 2019.009.18<br/> Цаг: 11 цаг 00 минут</p>   |
| ТООЗ 6.2                       | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь багцгүй</p> <p>Дотоодын давуу эрх тооцно.</p>   |

## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Хээлтэгч нь, өвчин эмгэггүй болохыг мэргэжлийн байгууллагаар баталгаажсан байна.
2. Нийлүүлэх эм төлөг тус бүр нь малыг ялган тэмдэглэх, мэдээллийн нэгдсэн сан сүлжээнд бүртгэгдсэн үржлийн гэрчилгээтэй буюу им тэмдэгтэй байна.
3. Тухайн хонины аж ахуйд сүүлийн 3 жилд шүлхий өвчин, 1 жил паразит өвчин, сүүлийн 20 хоног боом өвчин гараагүй байх.
4. Нийлүүлэх эм төлөг тус бүрд сүүлийн 6 сарын дотор тарьсан вакцины нэр, төрөл, тун, тарилга хийсэн он, сар, өдөр, вакцин үйлдвэрлэгчийн нэр хаяг зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлсэн байх

### 1. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

Тав: Ажлын тоо хэмжээ

| № | Барааны нэр, тодорхойлолт | Тоо, хэмжээ | <sup>1</sup> Нийлүүлэх хуваарь<br>_____ <sup>2</sup> хойш /, долоо<br>хоног, сараар/ |
|---|---------------------------|-------------|--|
| 1 | Төллөх насны эм хонь      | 160         | 14 хоног   |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
  - 1.1 Нийлүүлэгч нь эм хонийг хүлээлгэн өгөхдөө стандартад нийцэж буй эсэх, хээлтэй эсэх, өвчин эмгэггүй болохыг мэргэжлийн байгууллагаар шалгуулан захиалагчид хүлээлгэн өгнө. Энэхүү үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
  - 2.1 Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
    - 1) Өвчин эмгэггүй, хээлгүй байхыг нотолсон бичиг /энэхүү бичигт төллөх хугацааг тооцон тусгана./;
    - 2) ЗДТГ-ын дансанд бүртгэгдэх тул им, тэмдгийн цуваа, жагсаалттай байх.

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
  - 5.0 Баталгаат засварын тусгай шаардлага  
Нийлүүлэгч нь үржлийн эм хонь тус бүрийг хээлгүй болохыг баталж ирүүлсэн бичигт
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
  - Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
    - 7.1 Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт

1.Бараа хүргэх газар:Дорнод аймгийн Баяндун сумын нутаг дэвсгэрт сууриалан байршуулах.

бичгийг үндэслэн төлнө.

**5. Алданги оногдуулах (ГЕН - 11)<sup>3</sup>**

11.1 Алданги оногдуулах хувь: Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанаас хэтэрсэн хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,5 хувь.

Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй.

**Долоо: ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

**Баяндун сумын Засаг дарга Х.Хүрэлчулуун танаа**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл          | Тодорхойлолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1                  | 2            | 3                         | 4          | 5        | 6        | 7                             | 8        |
|                    |              |                           |            |          |          |                               |          |
|                    |              |                           |            |          |          |                               |          |
| Тендерийн нийт үнэ |              |                           |            |          |          |                               |          |

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр: \_\_\_\_\_

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга \_\_\_\_\_

Албан тушаал, нэр: \_\_\_\_\_

\_\_\_\_\_

Хаяг: \_\_\_\_\_

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх**
  - 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
2. **Төслийн менежерийн шийдвэр**
  - 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
3. **Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх**
  - 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
4. **Аюулгүй байдал**
  - 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
  - 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
5. **Зааварчилгаа**
  - 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
6. **Маргааныг шийдвэрлэх**
  - 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
- Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**
  7. **Ажлын хөтөлбөр**
    - 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
    - 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
  8. **Зөрчил, гологдол илрүүлэх**
    - 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд

хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

- 9. Зөрчил, гологдол арилгах**
- 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа<sup>4</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>5</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.

<sup>4</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

<sup>5</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.



Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

**17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**

- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

**18. Гэрээг цуцлах**

- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**

- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээс  
чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

**Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**

|                 |   |
|-----------------|---|
| <b>ГЕН 2.1</b>  | Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>[Тендерийн урилгад заасан нэр болон дугаар]</i>  |
| <b>ГЕН 2.1</b>  | Ажил нь <i>[товч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]</i> -аас бүрдэнэ.<br><br>Ажлын талбай нь <i>[байршил]</i> -д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.   |
| <b>ГЕН 3.1</b>  | Төслийн менежер нь <i>[томилогдсон этгээдийн нэр, хаяг]</i>   |
| <b>ГЕН 4.1</b>  | Ажил эхлэх өдөр <i>[огноо]</i><br><br>Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>[огноо]</i> <sup>6</sup>   |
| <b>ГЕН 7.1</b>  | Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>[тоо]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.   |
| <b>ГЕН 9.1</b>  | Чанарын баталгаат хугацаа <i>[тоо]</i> хоног байна.   |
| <b>ГЕН 13.1</b> | Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[хувь]</i> байна. <sup>7</sup><br><br>Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[хувь]</i> байна.   |
| <b>ГЕН 17.1</b> | Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө.<br><br>Гүйцэтгэлийн зургийг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө.<br><br>Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[мөнгөн дүн]</i> байна. |
| <b>ГЕН 19.1</b> | Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[хувь]</i> -иар тооцно.   |

<sup>6</sup> Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

<sup>7</sup> Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.



# ГЭРЭЭНИЙ МАЯГТ

## ЗАХИАЛАГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

## ГҮЙЦЭТГЭГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

**1.** Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

**2.** Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

**3.** Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/  
Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

**4.** Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай/\_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдөр ашиглалтад оруулна.

**5.** Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;

- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;  
**5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

**6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

**7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

**8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

**9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

